



**УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 3/70

Улаанбаатар хот

В.Батцэцэгийг ажлаас чөлөөлөх,
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, компанийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тээвэр үйлчилгээний албаны жолооч Вандагийн Батцэцэг /121429/ нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тул 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. В.Батцэцэгийн эрчим хүчний салбарт 36 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672 000/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 48 384 000 /дөчин найман сая гурван зуун наян дөрвөн мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

3. Нэг удаагийн тэтгэмжийг 48 384 000 /дөчин найман сая гурван зуун наян дөрвөн мянга/ төгрөгөөр, ээлжийн амралтын олговрыг 14.52 хоногоор тооцож олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

4. В.Батцэцэгийн ажлыг нэгж дотроо хүлээлцүүлж, холбогдох тооцоог хийж дуусгахыг Тээвэр үйлчилгээний албаны дарга /Б.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН